



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/204/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: Boldbaatarakh@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас:91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2023.02.23 № 105

танай _____ -ны № _____ -т

УРГАМАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ О.МӨНГӨНТУУЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн санхүүжилтээс 2,877.4 сая төгрөгийн, орон нутгийн санхүүжилтээс 414.8 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 12,0 сая төгрөгийн, нийт 3,304.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж гүйцэтгээгүй, илтгэх хуудас бичээгүй, тооллогын тооцоо бодоогүй байна.

013020167

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,021,394.88	109,789,704.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,631,035.55	42,254,576.66
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	110,631,035.55	42,254,576.66
3121	Төгрөг	110,631,035.55	42,254,576.66
31211	Төрийн сангийн харилцах	110,631,035.55	42,254,576.66
33	АВЛАГА	745,300.00	571,413.29
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,000.00	571,413.29
335	Бусад авлага	545,300.00	
3351	Байгууллагаас авах авлага	545,300.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	55,645,059.33	66,963,714.55
351	Түүхий эд материал	13,144,449.15	13,148,864.15
3511	Тусгай зориулалттай материал	12,661,449.15	12,901,864.15
3513	Эм боох материал	483,000.00	247,000.00
353	Бэлэн бүтээгдэхүүн		5,187,500.00
354	Хангамжийн материал	42,500,610.18	48,627,350.40
3541	Бичиг хэргийн материал	829,945.00	648,450.00
3542	Аж ахуйн материал	28,814,333.18	32,435,915.98
3543	Сэлбэг хэрэгсэл		880,000.00
3544	Түлш, шатах тослох материал	232,000.00	232,000.00
3545	Барилгын засварын материал	1,124,250.00	895,200.00
3546	Хүнсний материал	691,790.00	2,117,000.00
3547	Бусад хангамжийн материал	10,808,292.00	11,418,784.42
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	472,235,116.28	467,928,637.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,235,116.28	467,928,637.98
392	Биет хөрөнгө	412,780,741.28	408,886,762.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	442,997,556.00	442,997,556.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(150,705,812.52)	(174,498,745.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,335,000.00	16,335,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,584,999.82)	(15,084,999.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,593,792.02	186,815,860.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,970,842.06)	(108,907,161.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,255,717.22	92,395,717.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,385,956.24)	(56,219,308.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,441,200.00	9,441,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,361,713.48)	(6,175,394.88)
39217	Ном	21,166,800.16	21,787,039.66
393	Биет бус хөрөнгө	59,454,375.00	59,041,875.00

39301	Програм хангамж	2,400,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,265,625.00)	(1,678,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,320,000.00	58,320,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	639,256,511.16	577,718,342.48
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	985,100.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	985,100.00	
413	Өглөг	985,100.00	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	110,000.00	
4136	Бусад өглөг	875,100.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	424,600.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	450,500.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	638,271,411.16	577,718,342.48
51	Засгийн газрын хувь оролцоо	638,271,411.16	577,718,342.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	436,727,137.20	436,727,137.20
51101	Өмч: - төрийн	436,727,137.20	436,727,137.20
512	Хуримтлагдсан үр дүн	(129,345,067.19)	(189,898,135.87)
5121	Өмнөх үеийн үр дүн	(129,345,067.19)	(129,345,067.19)
5122	Тайлант үеийн үр дүн		(60,553,068.68)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	330,889,341.15	330,889,341.15
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	639,256,511.16	577,718,342.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	862,975,770.01	776,596,214.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,960,470.01	33,300,714.92
120	Нийтлэг татварын бус орлого	38,960,470.01	33,300,714.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,159,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,159,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,513,468.01	27,332,307.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,447,002.00	4,808,907.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	824,015,300.00	743,295,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	638,963,500.00	609,266,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	638,963,500.00	609,266,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	185,051,800.00	134,029,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	185,051,800.00	134,029,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	717,085,191.19	837,149,283.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,085,191.19	837,149,283.60

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,360,436.87	812,189,509.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,520,771.78	510,836,494.27
210101	Үндсэн цалин	297,647,476.00	368,598,327.27
210102	Нэмэгдэл	91,218,443.68	121,262,344.00
210104	Урамшуулал	21,654,852.10	20,975,823.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,820,417.77	64,059,701.33
210201	Тэтгэврийн даатгал	35,813,096.19	43,622,727.63
210202	Тэтгэмжийн даатгал	4,017,818.13	4,571,125.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,204,581.51	4,636,281.09
210204	Ажилгүйдлийн даатгал	792,282.32	1,011,321.31
210205	Эрүүл мэндийн даатгал	7,992,639.62	10,218,245.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,965,165.68	128,333,475.41
210301	Гэрэл, цахилгаан	7,346,165.68	7,556,557.45
210302	Түлш, халаалт	123,419,000.00	120,776,917.96
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	12,872,666.00	9,076,262.20
210401	Бичиг хэрэг	2,250,350.00	2,827,995.00
210402	Тээвэр, шатахуун	6,789,950.00	3,410,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,832,366.00	2,838,267.20
2105	Нормативт зардал	37,366,222.00	39,719,490.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	551,230.00	345,150.00
210502	Хоол, хүнс	36,814,992.00	39,374,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,046,500.00	3,736,000.00
210604	Урсгал засвар	1,046,500.00	3,736,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,573,750.00	2,809,000.00
210702	Дотоод албан томилолт	1,573,750.00	2,809,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	422,623.00	6,251,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,623.00	2,835,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	1,975,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,772,320.64	47,367,585.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,036,800.00	1,660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,522,700.00	1,418,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,212,820.64	44,288,785.80

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,724,754.32	24,959,774.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,151,320.00	24,143,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,151,320.00	24,143,650.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,573,434.32	816,124.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,573,434.32	816,124.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	145,890,578.82	(60,553,068.68)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	145,890,578.82	(60,553,068.68)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	824,015,300.00	744,455,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,159,500.00
120	Нийтлэг татварын бус орлого		1,159,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,159,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,159,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	824,015,300.00	743,295,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	638,963,500.00	609,266,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	638,963,500.00	609,266,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	185,051,800.00	134,029,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	185,051,800.00	134,029,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	704,091,264.45	800,181,458.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,091,264.45	800,181,458.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,087,910.13	769,159,084.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,613,871.68	511,020,236.27
210101	Үндсэн цалин	295,976,237.00	362,811,522.27
210102	Нэмэгдэл	92,979,682.68	125,148,230.00
210104	Урамшуулал	21,657,952.00	23,060,484.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,820,417.77	64,357,372.62
210201	Тэтгэврийн даатгал	35,799,876.77	43,848,870.23
210202	Тэтгэмжийн даатгал	4,017,815.13	5,127,544.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,217,801.97	4,101,715.09
210204	Ажилгүйдлийн даатгал	792,284.28	1,024,255.41
210205	Эрүүл мэндийн даатгал	7,992,639.62	10,254,987.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,325,515.68	129,213,475.41
210301	Гэрэл, цахилгаан	5,971,265.68	8,455,021.75
210302	Түлш, халаалт	145,404,250.00	119,877,400.00
210303	Цэвэр, бохир ус	950,000.00	881,053.66
2105	Нормативт зардал	37,699,060.00	40,254,250.00
210502	Хоол, хүнс	37,699,060.00	40,254,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,291,300.00	3,999,400.00

210604	Урсгал засвар	2,291,300.00	3,999,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	3,617,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,041,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	2,575,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,917,745.00	16,697,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,714,800.00	11,760,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,202,945.00	4,936,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,003,354.32	31,022,374.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,429,920.00	30,206,250.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,429,920.00	30,206,250.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,573,434.32	816,124.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,573,434.32	816,124.59
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	119,924,035.55	(55,726,458.89)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,293,000.00	12,650,000.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	9,293,000.00	12,650,000.00
	Дотоод эх үүсвэрээр	9,293,000.00	12,650,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,293,000.00	12,650,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,293,000.00)	(12,650,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	110,631,035.55	(68,376,458.89)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,631,035.55
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		42,254,576.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.12	(275,240,891.98)	492,375,586.34
7	Тайлант үеийн үр дүн			145,895,824.82	145,895,824.82
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.15	(129,345,067.19)	638,271,411.16
17	Тайлант үеийн үр дүн			(60,553,068.68)	(60,553,068.68)
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	436,727,137.20	330,889,341.15	(189,898,135.87)	577,718,342.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	855,085,000.00	812,831,458.89	42,253,541.11	95.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	855,085,000.00	800,181,458.89	54,903,541.11	93.58

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,989,500.00	769,159,084.30	52,830,415.70	93.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,992,600.00	511,020,236.27	30,972,363.73	94.29
210101	Үндсэн цалин	380,203,700.00	362,811,522.27	17,392,177.73	95.43
210102	Нэмэгдэл	140,867,700.00	125,148,230.00	15,719,470.00	88.84
210104	Урамшуулал	20,921,200.00	23,060,484.00	(2,139,284.00)	110.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,749,200.00	64,357,372.62	3,391,827.38	94.99
210201	Тэтгэврийн даатгал	46,069,500.00	43,848,870.23	2,220,629.77	95.18
210202	Тэтгэмжийн даатгал	5,419,900.00	5,127,544.14	292,355.86	94.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,335,900.00	4,101,715.09	234,184.91	94.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,084,000.00	1,024,255.41	59,744.59	94.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,839,900.00	10,254,987.75	584,912.25	94.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,029,000.00	129,213,475.41	815,524.59	99.37
210301	Гэрэл, цахилгаан	9,114,400.00	8,455,021.75	659,378.25	92.77
210302	Түлш, халаалт	119,877,400.00	119,877,400.00		100.00
210303	Цэвэр, бохир ус	1,037,200.00	881,053.66	156,146.34	84.95
2105	Нормативт зардал	40,256,400.00	40,254,250.00	2,150.00	99.99
210502	Хоол, хүнс	40,256,400.00	40,254,250.00	2,150.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	3,999,400.00	600.00	99.99
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,999,400.00	600.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,333,400.00	3,617,300.00	716,100.00	83.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,041,500.00	1,041,500.00		100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,291,900.00	2,575,800.00	716,100.00	78.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,628,900.00	16,697,050.00	16,931,850.00	49.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,691,100.00	11,760,400.00	16,930,700.00	40.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,937,800.00	4,936,650.00	1,150.00	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,095,500.00	31,022,374.59	2,073,125.41	93.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,095,500.00	30,206,250.00	2,889,250.00	91.27
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,095,500.00	30,206,250.00	2,889,250.00	91.27
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		816,124.59	(816,124.59)	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		816,124.59	(816,124.59)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		12,650,000.00	(12,650,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		12,650,000.00	(12,650,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	855,085,000.00	744,455,000.00	110,630,000.00	87.06
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,426,000.00	609,266,500.00	1,159,500.00	99.81
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,426,000.00	609,266,500.00	1,159,500.00	99.81

132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,029,000.00	134,029,000.00		100.00
132001	Орон нутгийн төсвөөс	134,029,000.00	134,029,000.00		100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	110,630,000.00	1,159,500.00	109,470,500.00	1.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,159,500.00	(1,159,500.00)	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	110,630,000.00		110,630,000.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		110,631,035.55	(110,631,035.55)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		42,254,576.66	(42,254,576.66)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.00	31.00		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31.00	31.00		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулан цогцолбор сургуулийн хэлбэрээр ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан гэсэн 32 орон тоо батлагдсан байна.

Эрхэм зорилт: Бага дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 онд “сурлагын хоцрогдолгүй бүтээлчээр хамтран суралцаж, зөв төлөвшил эзэмшье” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй ба сургуулийн захирал төрийн сангийн дарга мэргэжилтэнгүүд хяналт хэрэгжүүлж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,538.20 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	55,645.10	66,963.70	11,318.6
Үндсэн хөрөнгө	790,510.10	830,492.30	39,982.2
Нийт хөрөнгө	639,256.50	577,718.30	(61,538.2)
Өр төлбөр	985.1	0.00	(985.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	638,271.40	577,718.30	(60,553.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	639,256.50	577,718.30	(61,538.2)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 55,645.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 83,925.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,808.9 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 77,415.7 мянган төгрөгийн материал зарцуулж, бараа материалын эцсийн үлдэгдэл 66,963.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,318.60 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 12,650.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 27,332.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, актласан үндсэн хөрөнгө байхгүй байна. Жилийн эцэст 577,718.30 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 44,288.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 61,538.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 610,426.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 134,029.0 мянган төгрөг,

нийт зарлагыг 744,455.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 610,426.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 609,266.5 мянган төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
81605	Эрүүл мэндийг дэмжих	1,809.70	1,809.70	-	100%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,581.30	12,650.00	3,931.30	77%
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	2,962.70	2,862.00	100.70	96,6%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	475,175.40	456,557.80	18,617.60	96%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	114,684.00	109,367.80	5,316.20	95%
Орон нутгийн төсвөөс санхүүжих		610,426.00	609,266.50	1,159.50	99,8%
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	134,029.00	134,029.00		100%
НИЙТ		744,455.00	743,295.50		99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж, 134,029.0 мянган төгрөгийг тогтмол зардалд зарцуулсан байна.

4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Мах	20,000.00	20,000.00
2	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Хүнсний ногоо	2,510.00	2,510.00
3	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Сүү, цагаан идээ	1,310.00	1,310.00
4	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – бусад хүнсний материал	12,436.40	12,436.40

5	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Талх, нарийн боов	4,000.00	3,890.10
5	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	119,877.40	119,877.40
6	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	9,114.00	8,455.10
7	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	1,037.20	881.10
8	Шууд худалдан авалт	Урсгал засвар	4,000.00	3,999.40
12	Шууд худалдан авалт	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ	4,937.80	4,936.70
ДҮН			179,222.80	178,296.20

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Аудитыг “Ари финайнс аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг “Ари финайнс аудит” ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари финайнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 358,950.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,384.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,038.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ургамал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж, аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Зөвлөмж	1	5,600.0	1	5,600.0	100%
Нийт дүн	1	5,600.0	3	5,600.0	100%

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг тодохойлоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил тогтоогдоогүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

АРИ ФИНАЙНС АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2024-02-22

